

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА, ТАНИЛЦУУЛГА

2025.08.15

Нэг."Тогтоол гаргах үндэслэл, шаардлага зорилго"

Үндэслэл шаардлага: Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д "Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, ААН байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө", Хог хаягдлын тухай хуулийн 41.6-д "Айл өрхийн хэрэглээнээс үүссэн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно" гэж заасан.


2024 оны жилийн эцсийн байдлаар 123,3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 966,6 сая төгрөгийн зарлага гарсан бөгөөд нийт зарлагын 11 %-ийг бүрдүүлж байгаа нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг зайлшгүй нэмэгдүүлэх, үйлчилгээний зардлыг иргэнээр тооцож бодитоор бүрдүүлэх шаардлага тулгарсан. Мөн бараа материал, түлш шатахуун үнийн өсөлт 2013 оноос хойш 2-3 дахин өссөн, Хог хаягдлын тухай хууль шинэчлэн батлагдаж, айл өрхөөс иргэнээс тооцож, хог хаягдлын хураамжийн хэмжээг бодитой тооцох нөхцлийг бүрдүүлсэн.

Орлого жилээр /төгрөг/	Зарлага жилээр /төгрөг/
Айл өрхөөс 54,791,125 төгрөг	Цалин 489,057,624 /Ачигч, жолооч нар/
ААН 86,570,000	Шатахуун 232,600,229
	Сэлбэг 147,148,980
	Бараа мат 16,696,100
	Элэгдэл 81,106,250
Нийт орлого- 123,361,125	Нийт зардал 966,609,183



Түлш шатахууны үнийн өсөлт, өөрчлөлт

№	Барааны нэр, төрөл	2013	2025/төгрөг/
4	Бензин, А-92, 1 л	1640	2 760
5	Дизелийн түлш, л	1910	3 250



2024 онд Баруун-Урт сум 7243 өрх, 24915 хүн ам тоологдсон.

Дунджаар нэг өрхөд 3,4 буюу 3 иргэнтэй гэж үзвэл сард нэг өрхөөс 6774 төгрөг гэсэн тооцоолол гарч байна.

Цахим болон цаасан судалгаагаар Баруун-Урт суманд **ам бүлийн тоо 4-6 нийт санал асуулгын 53,4** хувийг эзэлж байна.

Иймд хог хаягдлын тухай хуулийн дагуу нэг иргэнээр тооцож хог хаягдлын үйлчилгээний хураамжийг авах нь зүйтэй юм.

Цахим болон цаасан санал асуулга 2024 оны 3 сараас эхлэн иргэдээс санал авч эхэлсэн. **Нийт давхардсан тоогоор 4068 иргэн** санал өгсөн



Сүхбаатар Тохижилт Үйлчилгээ

...

Mar 25, 2024 · 🌐

Иргэд та бүхэн хог хаягдлын үйлчилгээний хураамж, тарифт өөрчлөлт оруулах талаарх санал асуулгад идэвхтэй оролцоно уу.




docs.google.com

Хог хаягдлын үйлчилгээний хураамж, тарифт өөрчлөлт ...

Цахим санал асуулгад нийт 1901 иргэн хамрагдсан. 840 иргэн буюу 44,2 хувь нь 10,000 төгрөг болгохыг дэмжсэн байна. 52,3 хувь нь 4-6 иргэнтэй.


Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сард хэдэн төгрөг болгохыг дэмжиж байна вэ.

1,853 responses




3. Ам бүлийн тоо

1,883 responses




1. Та хэдэн настай вэ?

1,893 responses




Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сард хэдэн төгрөг болгохыг дэмжиж байна вэ.

1,853 responses




2. Хэддүгээр багийн иргэн бэ?

1,901 responses




3. Ам бүлийн тоо

1,883 responses




4. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, тарифыг нэмэх шаардлагатай эсэх.

1,901 responses




Цаасан судалгааг ААНБ болон айл өрхөөр явж судалгаа авсан нийт **1647 иргэн** хамрагдсан. 10,000 төгрөгийг 792 иргэн дэмжсэн байна. Ам бүлийн тоо 4-6 иргэн нь илүү байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сард нэг өрхийн хэдэн төгрөг болгохыг дэмжиж байна вэ?



Мөн 2025 оны 6-р сарын 5-6-ны өдрүүдэд Баруун-Урт сумын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 9-р багийн ИНХурлын хэлэлцэх асуудалд оруулж иргэдэд хог хаягдлын үйлчилгээний тариф нэмэгдүүлэх талаарх мэдээ мэдээлэл хүргэж сонсох ажиллагааг явуулж, санал авсан.



Хог хаягдлын үйлчилгээний хураамж, тарифт өөрчлөлт оруулах талаарх санал асуулга

Ерөнхий мэдээлэл

Айл өрхийн хог тээвэрлэлтийн үйлчилгээний хураамж, үнэ тарифыг Баруун-Урт сумын ИТХ-ын 2013 оны 04 тоот тогтоолоор сард орон сууцны айл өрхөөс 2500 төгрөг, гэр хорооллын нэг өрхөөс 2500 төгрөг гэж тогтоон мөрдөж байна.

2013 оноос хойш шатахууны зардал 2,1 дахин, дулаан, цахилгааны үнэ 2,6 дахин, цалин хөлс 2,6 дахин тус тус өссөн нь хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булшлахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй, гарсан бодит зардлын 50 хувийг нөхөж чадахгүй, алдагдалтай ажиллаж байгаагаас тухайн тогтоолыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тулгарч байна.

2023 оны жилийн эцсийн мэдээгээр 7017 өрх, 24353 хүн ам тоологдсон.

Хууль эрх зүйгээс...

Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д "Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, ААН, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө"

Хог хаягдлын тухай хуулийн 41.6-д "Айл өрхийн хэрэглээнээс үүссэн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно" гэж заасан тул Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192/A243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал"-ын дагуу тооцоход нэг иргэн сард 2258 төгрөг төлөх тооцоолол гарч байна. Жишээ нь: /Батынх 4 ам бүлтэй бол өрхийн нэг гишүүн 2258 төг буюу өрх сард нийт 9032 төг төлнө./

Өнөөгийн байдлаар Баруун-Урт сум нь бусад аймаг, хотуудтай харьцуулахад хамгийн хямд үнээр хог хаягдлыг ачиж тээвэрлэж байна. Энэхүү санал асуулгын үр дүнг харгалзан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, үнэ тарифыг сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж, эцэслэн шийдвэрлэнэ.

1. Та хэдэн настай вэ?

- ✓ 18-35
- ✓ 36-50
- ✓ 51-ээс дээш нас

2. Хэддүгээр багийн иргэн бэ?

- ✓ 1 дүгээр баг
- ✓ 2 дугаар баг
- ✓ 3 дугаар баг
- ✓ 4 дүгээр баг
- ✓ 5 дугаар баг
- ✓ 6 дугаар баг
- ✓ 7 дугаар баг
- ✓ 8 дугаар баг
- ✓ 9 дүгээр баг

3. Ам бүлийн тоо

- ✓ 1-3
- ✓ 4-6
- ✓ 6 дээш

4. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, тарифыг нэмэх шаардлагатай эсэх.

- ✓ Тийм
- ✓ Үгүй

5. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сард нэг өрхийн хэдэн төгрөг болгохыг дэмжиж байна вэ?

- ✓ 1 сард 6000 төгрөг
- ✓ 1 сард 8000 төгрөг
- ✓ 1 сард 10000 төгрөг

6. Иргэн та хог хаягдлын үйлчилгээний хураамж, үнэ тарифын талаарх санал, хүсэлтээ бичнэ үү.

.....

.....

.....

Бидний ажлыг дэмжин саналаа өгсөн танд баярлалаа.

Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ

Иргэдээс гарсан саналыг голчлон дурдвал:

- ❖ Хураамжийг иргэн бүрээс биш, өрхөөр тооцож 100 хувь авах
- ❖ Тогны мөнгөн дээр авах
- ❖ Хогийн савны хүртээмжийг сайжруулах
- ❖ Гэр хорооллын хог зөөврийг сард 2 удаа болгох

Зорилго: Айл өрхийн хог тээвэрлэлтийн үйлчилгээний хураамж, үнэ тарифыг Баруун-Урт сумын ИТХ-ын 2013 оны 04 дүгээр тогтоолоор орон сууц болон гэр хорооллын нэг өрхөөс сард 2500 төгрөг гэж тогтоон өнөөдрийг хүртэл мөрдөн ажиллаж байна. Монгол Улсын “Хог хаягдлын тухай”/2017/ хуулийн шинэчилсэн найруулгын 9.2.1-д энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах, 9.2.2-т байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох нь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх болохыг заасан. Иймд “Хог хаягдлын тухай” болон холбогдох хууль, дүрэм, журмын шинэ заалтуудтай нийцүүлэх, хог тээвэрлэлт, устгал, дахин боловсруулах үйл ажиллагааны бодит өртөг нэмэгдэж буй тул хураамжийг шинэчилснээр үйлчилгээний зардлыг бодитоор нөхөх боломж бүрдүүлэх, санхүүжилт нэмэгдсэнээр үйлчилгээний чанарыг сайжруулах, технологийн сайжруулалт хийх, Хог хаягдлын тухай хууль, журмын хэрэгжилтийг хангах нөхцлийг бүрдүүлнэ. Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ тогтоох аргачлалаар тооцоход 2258 төгрөг гарсан бөгөөд тогтоолыг хэрэгжүүлэгч тохижилт үйлчилгээний байгууллагын актын төсөлд 2500 төгрөгөөр саналыг оруулж, сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 6/06 тогтоолоор 2500 төгрөгөөр шинэчлэн баталсан.

Хог хаягдлын тухай хуулийн 41.6-д “Айл өрхийн хэрэглээнээс үүссэн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно” гэж заасан. Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192/А243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ын дагуу тооцоход нэг иргэн сард **2258 төгрөг** төлөх тооцоолол гарсан.

	Үзүүлэлт	Нэгж	Тайлбар
А	Хүн амын тоо	24915	2024 оны эцсийн статистик тоо
В	Иргэнээс өдөрт үүсэх хог хаягдлын хэмжээ	3,9кг	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалтын дагуу

C	Нэг жилд сууринд үүсэх хог хаягдлын хэмжээ	35466тн	$C=(A*B)*365/\text{нэг жил}$
D	Нэг тн хог хаягдлыг цуглуул, тээвэрлэх зардал	10571 төгрөг	Сүхбаатар аймгийн ИТХ 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан
E	Нэг тонн хог хаягдлыг төвлөрсөн цэгт дарж булаж устгах зардал	8464 төгрөг	
F	Нэг жилд үүсэх хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах нийт зардал	675104875 төгрөг	$F=(D+E)*C$
G	Сарын нэг иргэнд ногдох хог хаягдлын үйлчилгээний хураамж	2258 төгрөг	$G=(F/12)/A$

2024 онд Баруун-Урт сум 7194 өрх, 24915 хүн ам тоологдсон. Баруун-Урт сумын төвд 6195 өрх, 22474 иргэн амьдарч байна. Дунджаар нэг өрхөд 3,4 буюу 3 иргэнтэй гэж үзвэл сард нэг өрхөөс 6774 төгрөг гэсэн тооцоолол гарч байна.

Цахим болон цаасан судалгаагаар Баруун-Урт суманд ам бүлийн тоо 4-6 нийт санал асуулгын 53,4 хувийг эзэлж байна.

Иймд хог хаягдлын тухай хуулийн дагуу нэг иргэнээр тооцож хог хаягдлын үйлчилгээний хураамжийг авах нь зүйтэй юм.

Хог хаягдлын хураамж төлөх иргэдийн тооцоолол :

	Өрхийн тоо	Хүн ам	Тогтоосон хураамжийн хэмжээ	Үйлчилгээний хураамжийн орлого
Аймгийн төвд	6195	22474	2500 төг	56,185,000/1 сард/
Хөдөө	999	2441		

ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН:

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг нэмэгдүүлснээр тохижилт, үйлчилгээний чанар дээшилж, орлого өссөнөөр төрөөс авах дэмжлэг, татаасны хэмжээ багасах боломж бүрдэнэ. Мөн хог тээврийн машины үйлчилгээг нэмэгдүүлэх, машин техник, ажилчдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах замаар хөдөлмөрийн бүтээмж өсөж, хүний нөөц тогтворжино. Үйлчилгээний чанар, хүртээмж ахиснаар хотын өнгө үзэмж сайжирч, иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэх давуу талтай.

Тогтоол батлагдсанаар Иргэн бүр хог хаягдлын хураамжийг эрх тэгш, ижил төлөх бөгөөд, Хог хаягдлын хуулийн хэрэгжилт хангагдаж, сумын төсөвт орох орлогын хэмжээ нэмэгдэж, хог хаягдлын тухай хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулагдах болно.

**БАРУУН-УРТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
..... ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

..... оны сарын өдөр

Дугаар

Баруун-Урт

Хог хаягдлын үйлчилгээний хураамж
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хурлаас ТОГТООХ нь:

1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн шинэчлэн батлагдсан үнэ, тарифыг иргэдэд мэдээлж, төлбөрийг төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэн зохих журмын дагуу зарцуулж хагас жил, жилээр биелэлт, үр дүнг сумын Засаг даргад танилцуулж ажиллахыг “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга (Х.Баатарсүх)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Хүрэлтогоо)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Хүрэлтогоо)-д даалгасугай.

ДАРГА

Г. ИДЭРМӨНХ

Баруун-Урт сумын Иргэдийн
Төлөөлөгчдийн.....дүгээр хурлын
.....тогтоолын...дүгээр хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Хог гаргагч эх үүсвэрүүд	Хэмжих нэгж	Шинэчлэн боловсруулсан төлбөрийн хэмжээ хэмжээ/төгрөгөөр/
1.	Иргэн	сард	2500
2.	Мах боловсруулах үйлдвэр	сард	500,000
3.	Сургууль цэцэрлэг дотуур байр	сард	50,000
4.	Аймгийн нэгдсэн эмнэлэг	сард	150,000
5.	Өрхийн эмнэлэг	сард	30,000
6.	Эмийн сан	сард	75,000
7.	Албан байгууллага, ажлын өрөө	сард	30,000
8.	Сүм хийд, соёл, спорт үйлчилгээний газар	сард	30,000-50,000
9.	Худалдааны төв, зах, агуулах худалдаа, супер маркет	сард	100,000-200,000
10.	Хүнсний дэлгүүр	сард	50,000-75,000
11.	Бар ресторан	сард	100,000-150,000
12.	Цайны газар, үчин. гутал засвар. дугуй засвар, тоглоомын газар	сард	30,000-50,000
13.	Бүх төрлийн үйлчилгээний нэгдсэн төв	сард	350,000
14.	Зочид буудал	сард	30,000-75,000
15.	ШТС	сард	30,000